

ГАЗАРЗҮЙ БА ГЕОМОРФОЛОГ

ТАВТЫН РАЙОНЫ АЛТНЫ ХҮДЭРЖИЛТ ЦАГИРГАН
СТРУКТҮҮРТЭЙ ХОЛБООТОЙ БОЛОХ НЬЧ. АЛТАНЗУЛ¹, Я. БОЛД²¹Увсгал Геологи УБЖН, ²Монгол Улсын Их Сургууль

Булган аймгийн Тэшиг сумын нутагт хийгдсэн геологийн зураглал-ерөнхий эрлийн судалгааны явцад ажиглалт, агаарын гэрэл зураг болон топо зургийн тайлалтын үр дүнгээр Эг, Тавтын голуудын бэлчир орчимд тогтоогдсон цагирган структуртэй холбоотой алтны хүдэржилт үүссэн зүй тогтлыг илрүүлсэн. Морфоструктурийн шинжилгээ хийснээр өөр хоорондоо 100м-ийн өндрийн ялгавар бүхий 26 блокуудыг ялгаснаас Эг, Тавтын голын бэлчир орчимд цагирган структуртэй тогтоогдсон юм. Ер нь ашигт малтмалын бараг бүх төрлийн орд, илэрлүүдтөдөрхой морфоструктуртэй гарал үүсэл, орон зайн холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл ашигт малтмал нь геологи-тектоникийн тодрохой структурүүдэд байрлаж байдаг. Ялангуяа цагирган структур нь ашигт малтмалын ордын байрших, үүсэх (Я.Болд. 1987) нөхцлийг бүрдүүлдэг геологи-тектоникийн тогтоц болно. Судалгааны талбайд тогтоогдсон дээрх цагирган структур өмнөх судлаачдын сонирхолыг татаагүй орхигджээ (1-р зур). Энд А цэг дээр тус тогтоцын хамгийн их хүдэржилт бүхий Тавтын алтны үндсэн орд, Б цэг дээр Ар зорлогийн алт, сульфидийн илрэл, В цэг дээр Салхитын алт-зэсийн илрэл тус тус байрлаж байгаа нь харагдана.

Геологийн тогтоц

Тавтын орд. Ордын талбай нь дунд-хожуу кембрийн зэдийн бүрдлийн хожуу өрнөлийн гранодиоритоос тогтох бөгөөд төвийн хэсэгтээ түрүү өрнөлийнхөө диоритын үрдэгдэл

биетүүдийг агуулсан байдаг. Талбайн зүүн болон баруун хойд хэсгээр зэдийн бүрдлийн боржин диоритыг зүссэн хожуу перм-түрүү триасын сэлэнгийн бүрдлийн түрүү болон хожуу өрнөлийн сиенит, шүтлэгдүү лейкоборжин хөгжсөн байна. Ордын хэмжээнд ихэвчлэн зүүн хойш чиглэлтэй кварц, сиенит, боржин, монцодиоритын дэл судлын чулуулаг өргөн тархжээ.


Хүдэржилт нь зэдийн бүрдлийн гранодиоритод байрших кварц-алтын судлуудтай холбоотой.

Ар Зорлогийн илрэл. Талбайд доод кембрийн бургалтайн дээд дэд свитийн атираашилд хүчтэй автсан элсжин, тоосжин зонхилсон андезит, шохойжины үе мэншлийг агуулсан олигомикт-флишойд хурдас тархсан бөгөөд дээрх хурдсыг зүсэж дунд девоны тэсийн бүрдлийн түрүү өрнөлийн сиенит, кварцат сиенит илэрдэг. Мараат-Ам, Улаан чулуут голын хооронд дунд девоны түрүү өрнөлийн сиенитийг зүссэн хожуу перм-түрүү триасын сэлэнгийн бүрдлийн шүтлэгдүү лейкоборжингийн жижиг биет тогтоогджээ.

Хүдэржилт нь дунд девоны тэсийн бүрдлийн түрүү өрнөлийн сиенит доторх хагарлын бүсүүдтэй холбоотой гидротермаль-пневматолит уусмалаар нэвчсэн хувирлын бүсүүд, суларлын бүсүүдийн дагуу гарч ирсэн 30-45°-ын уналтай дэвүүр маягийн дэл судлын чулуулгуудтай холбоотой гэж үзэж байна.

Салхитын илрэл. Илрэлийн хэмжээнд венд-кембрийн бадарын голын метавулканидууд, хожуу перм-

Масштаб 1:400.000



Зур.1 Тавтын алтны ордын морфоструктурын бүдүүвч

1-Блок хязгаарлагч хагарал, 2-Цагирган тогтоц, 3-Голын сүлжээ, 4-Ашигт малтмалын орд, илрэлүүдийн байршил:

А-Тавтын орд, Б-Ар зорлогын илрэл, В-салхитын илрэл

түрүү триасын сэлэнгийн бүрдлийн түрүү өрнөлийн сиснит, дээд триас-доод юрийн могодын свитийн вулканоген терриген хурдас тархсан. Могодын свитийн хурдас нь тектоник хагарлаар бусад хурдас чулуулгаас тусгаарлагдаж байдаг. Хүдэржилт нь уг хурдастай орон зай, гарал үүслийн холбоотой кварц-хлорит-эпидотын метасоматит (профиллитжих) хувирлуудад үүссэн алт-зэсийн илрэл юм.

Дүгнэлт

Хэдийгээр орд илрэлүүдийн геологийн тогтоц, хүдэржилт нь

ялгаатай ч дээрх илрэлүүдийн байршил нь орон зайн хувьд цагирган стрүктүүртэй холбоотой гэж үзэж судлаачдын анхааралд хандуулав.

Зохиол

1.Я.Болд. Геоморфологийн үндэс ба судалгаа. Улаанбаатар, 1987 он

2.Ч.Уртнасан. Тавтын 1:50000-ны зураглал-ерөнхий эрлийн ажлын тайлан.